



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 43


Улаанбаатар хот

Г “Хаскредит” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тухай Т

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.5, Санхүүгийн зохицуулах хорооны 2015 оны 405 дугаар тогтоолоор баталсан “Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зохицуулалтын журам”-ын 5.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хаскредит” ХЗХ-ны хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2016 оны 4 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар сунгасугай.
2. Цаашид тусгай зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт болон бусад баримт бичиг, тайлан мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан хугацаанд Хороонд ирүүлж байхыг “Хаскредит” ХЗХ /Ц.Идэрхангай/-нд анхааруулсугай.
3. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралтад холбогдох тэмдэглэгээг 2017 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор хийлгэхийг “Хаскредит” ХЗХ /Ц.Идэрхангай/-нд үүрэг болгосугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

00120